



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/439


Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, шинжлэх ухааны яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2022 оны 06/2058 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг хавсралт ёсоор баталсугай.
2. Албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагын дагуу сонгон шалгаруулалт явуулж, дүнг танилцуулах, зохих томилгоо хийлгэх, шийдвэр гаргуулах арга хэмжээ авч ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, шинжлэх ухааны яамны дэргэдэх салбар зөвлөлд даалгасугай.


САЙД



Д.ЭНХ-АМГАЛАН

142211872

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2022 оны 11 сарын 02 өдрийн
АЧЗ тоот тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 11 дугаар сарын 02

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2022 оны 11 дугаар сарын 02

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Захирал

ТҮБД-5

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Улсын хэмжээнд олон улсын хөтөлбөртэй 4 сургууль, Үүнээс нийслэлд 3, орон нутагт 1.

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Бага, дунд боловсролын болон Олон улсын боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөр, технологи, аргазүй бүхий олон улсын хөтөлбөрийн сургалттай сургуулийг хөгжүүлэх, харьяалах аймаг, дүүргийн хэмжээнд багш нарын мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр сургалт-дадлагыг зохион байгуулах, бусад олон улсын хөтөлбөртэй сургуулиудад шинэ технологи, аргазүйн сургалтын технологийн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, захиргааны болон мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах, үр дүнг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:			
<p>1. Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний хөтөлбөрүүд болон бусад холбогдох захиргааны шийдвэрийн хэрэгжилтийг хангах, тайлагнах;</p> <p>2. Тухайн сургуулийн хөгжлийг төлөвлөх, бага, дунд болон олон улсын боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сургалтын арга зүй, технологийн судалгаа туршилтыг хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;</p> <p>3. Байгууллагын хүний нөөцийн бодлогыг оновчтой тодорхойлж, багшийн хөгжлийг тасралтгүй ханган чадавхыг сайжруулах,</p> <p>4. Суралцагчийн хөгжил төлөвшлийг дэмжих, эрүүл, аюулгүй таатай орчинд сурч, хүмүүжих нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>5. Төсөв, санхүүгийн удирдлагын үйл ажиллагааг эдийн засгийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын тогтолцоог ханган удирдах;</p> <p>6. Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p>			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийг баримтлан ажиллах;	Холбогдох бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг ханган хүрсэн үр дүнг тайлагнасан байна.	Ш, Х, Г
	2. Улсын Их Хурал, Засгийн газар, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан бодлого шийдвэр, дүрэм журам, чиглэл, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжүүлэх, тайлагнах;	Холбогдох бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг ханган хүрсэн үр дүнг тайлагнасан байна.	Ш, Х, Г
	3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад үндэсний хөтөлбөрүүдэд ерөнхий боловсролын талаар тусгасан бодлогыг хэрэгжүүлэх.	Хөтөлбөр, төлөвлөгөөний бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган хүрсэн үр дүнг тайлагнасан байна.	Ш, Х, Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Сургуулийг хөгжүүлэх хэтийн болон дунд хугацааны хөтөлбөр, жилийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, биелэлтийг дүгнэх, тайлагнах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Сургуулийн хэв шинж, онцлогт нийцүүлэн сургууль хөгжүүлэх хэтийн болон дунд богино хугацааны төлөвлөгөөг батлан хэрэгжилт, үр дүнг тайлагнасан байна.	Ш, Х, Г

<p>2. Сургалтын байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, иргэд олон нийтэд ил тод, нээлттэй мэдээллэх нөхцөл бүрдүүлэх;</p>	<p>Үр дүн, гүйцэтгэл нь байгууллагын хөгжлийг хангахад чиглэсэн байна.</p>	<p>Ш, Х, Г</p>
<p>3. Боловсролын баримт бичгийг захиалах, олгох ажлыг зохион байгуулах</p>	<p>Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.</p>	<p>Ш, Х, Г</p>
<p>4. Сургуулийн үйл ажиллагааны чанар, үр дүнг тандах судалгаа, оношлогоо, хэрэглэгчийн үнэлгээний ажлыг багш, ажилтан, сурагч, эцэг эх, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, хариу арга хэмжээ төлөвлөх, хэрэгжилтийг хангах;</p>	<p>Үйл ажиллагааны чанар хүртээмж дээшилсэн байна.</p>	<p>Ш, Х, Г</p>
<p>5. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч, зохих байгууллагад шаардлага тавьж хэрэгжүүлэх;</p>	<p>Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.</p>	<p>Ш,Х</p>
<p>6. Дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтын ажиллагаа, түншлэл тогтоох, бэхжүүлэх, хууль тогтоомжид нийцсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;</p>	<p>Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.</p>	<p>Ш, Г</p>
<p>7. Олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургуульд суурилсан менежмент, маркетинг хөгжүүлэх, сургалтын талаар баримтлах бодлого, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох, хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангах, багш, ажилтанд зөвлөн туслах, хамтран ажиллах;</p>	<p>Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.</p>	<p>Ш,Х</p>
<p>8. Олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичгийн судалгаа, арга зүй, үнэлгээний дэвшилтэт арга, хэлбэрийг турших, инновацийг нэвтрүүлэх ажлыг Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, тухайн орон нутгийн Боловсролын асуудал эрхэлсэн байгууллагын удирдлага дор хэрэгжүүлж, үр дүнг Боловсролын асуудал эрхэлсэн</p>	<p>Олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын судалгаа, арга зүйн туршилтыг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнасан байна.</p>	<p>Ш,Х,Г</p>

	төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;		
	9. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Боловсролын ерөнхий газар болон тухайн орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага, эцэг, эх, олон нийтийг мэдээллээр хангах, сургуулийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөг багш, ажилтан, сурагч, эцэг, эх, асран хамгаалагчдад сурталчилан таниулах;	Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	Х,Г
	10. Сурлагын амжилт, төгсөгчдийн чанар, боловсролын хүртээмж, үр дүнгийн үзүүлэлтийг тогтмол хянах, шинжилгээ хийх, тайлагнах.	Үнэн бодит мэдээллээр хангагдсан байна.	Х,Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Багшийн мэргэжил дээшлүүлэх, шинэ технологи, аргазүй эзэмшүүлэх сургалт-дадлагыг тухайн орон нутгийн Боловсролын ерөнхий газар, боловсролын асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран үндэсний болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг тогтмол хэрэгжүүлэх;	Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	Ш, Х, Г
	2. Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, багшийн мэргэжил, ур чадварын тасралтгүй хөгжлийг дэмжих орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байранд багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;	Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаа сайжирч шинэ технологи, аргазүй бий болсон байна.	Ш, Х, Г
	3. Хичээл, сургалтын зохион байгуулалт, сургалтын арга зүй, технологи, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, сургалтын орчны хөгжлийн асуудлаар багш, ажилтныг мэдээллээр хангах, судалгаа хийх, шилдэг арга зүй, технологийг сургалтад нэвтрүүлэх ажлыг дэмжих, зөвлөн туслах;	Шилдэг арга зүй, технологи сургалтад нэвтэрч, багш, ажилтны мэргэжил, ур чадварын хөгжилд ахиц, өөрчлөлт гарсан байна.	Ш, Х, Г

	4. Багш нарын зөвлөл, заах аргын нэгдлийн үйл ажиллагааны уялдааг хангах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, зөвлөн туслах;	Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулагдсан байна.	Ш, Х, Г
	5. Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, нөөцийг зөв байршуулах;	Байгууллагын алсын хараа, стратегийн зорилго зорилтонд нийцсэн хүний нөөцийн хөтөлбөр хэрэгжсэн байна.	Ш, Х, Г
	6. Багш, ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, ажилд томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;	Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	Ш, Х, Г
	7. Багш, ажилтны бүтээлч үйл ажиллагааг сурталчлан таниулах, урамшуулах, шилдэг арга зүй, технологи, менежмент, маркетинг, соёлыг боловсролын технологийн үндэсний санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, багш ажилтны хөдөлмөрийн гэрээ гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, үр дүн, ур чадварыг үнэлэх, урамшуулах, дэмжих, хариуцлага тооцох эрхзүйн орчныг бүрдүүлэх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Ш, Х, Г
	8. Багш ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх, багш, ажилтныг мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ зөрчих, авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;	Нийгмийн баталгааг хангах холбогдох ажлуудыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, удирдах ажилтан, багш, ажилтнууд ёс зүйн хэм хэмжээний зөрчилгүй ажиллана.	Ш, Х, Г
	9. Сургуулийн хэв шинж, бүтцийн нэгж, ангийн менежментийг оновчтой тогтоох, хичээл болон хичээлээс гадуурх сургалтын ажлыг чанартай зохион байгуулахад сургалтын менежер, багш нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, хамтран ажиллах;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Ш, Х, Г

	10. Багш нарын хичээл, сургалтын үйл явц, үр дүн, ур чадварын хөгжилд ажиглалт, судалгаа, шинжилгээ хийх, дэмжих арга хэмжээ төлөвлөх, хэрэгжүүлэх;	Багш, нарын ур чадварын хөгжилд ахиц, өөрчлөлт гарсан байна.	Ш, Х, Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Сурагчдыг сурах бичиг, дүрэмт хувцсаар хангах ажлыг холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотой зохион байгуулах;	Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	Ш, Х, Г
	2. Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, суралцагчийн суралцах, төлөвших, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх; чиглэлээр ажиллах;	Таатай орчин нөхцөл бүрдсэн байна.	Ш, Х, Г
	3. Суралцагчийн онцлог, хэрэгцээ, сонирхол, сурах чадамжид үндэслэн хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хичээлээр эзэмших мэдлэг, чадвар бүтээх, хичээл хоорондын уялдаа холбоог хангах, сургалтын аргуудыг оновчтой сонгох, хэрэглэх, анги, сурагчтай ажиллах үйл ажиллагааг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх, манлайлан оролцох, чиглүүлэх, зөвлөн туслах;	Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	Ш, Х, Г
	4. Цахим хэлбэрээр сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, цахим сургалтын орчинг бүрдүүлэх	Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	Ш, Х, Г
	5. Сургуулийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөх, болзошгүй эрсдэлд өртөхөөс болон гэмт хэрэг, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;	Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	Ш, Х, Г
	6. Сургуулийн үйл ажиллагаанд эцэг, эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулийн орчинд нийгэм-сэтгэл зүйн таатай уур амьсгал бүрдүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээг авах;	Эцэг, эх, олон нийтийн оролцоог ханган ажилласан байна.	Ш, Х, Г

	7. Багш нарын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн суралцагчийг анги дэвшүүлэх, алгасуулан суралцуулах, улируулах, сургууль төгсгөх, сургуулиас хасах, чөлөөлөх шийдвэрийг гаргах.	Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	Ш, Х, Г
5 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын төсвийн төсөөлөл, төсвийг төлөвлөх, батлуулах, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг тогтоосон хугацаанд удирдан зохион байгуулах;	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан байна.	Ш, Х
	2. Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг ил тод, нээлттэй, цаг хугацаанд нь мэдээлэх;	Мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан байна.	Ш, Х
	3. Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, статистикийн мэдээлэл, бусад шаардлагатай мэдээ, судалгаа, тайланг үнэн зөв тайлагнах, холбогдох байгууллага, албан тушаалтанд тогтоосон хугацаанд нь мэдээлэх, санхүүгийн зөрчилгүй ажиллах, тайлагнах ажлыг удирдлагаар хангах;	Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, тайланг тогтоогдсон цаг хугацаанд нь үнэн зөв гаргана.	Ш,Х
6 дугаар зорилтын хүрээнд	1. Удирдах дээд шатны байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх;	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна.	Х, Ш
	2. Эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах асуудлаар байгууллага, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангаж, тэднээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг судалж барагдуулах;	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргаж, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэсэн байна.	Г, Х,Ш
	3. Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг архивын нэгж болгон хадгалуулах;	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Г, Х
	4. Засгийн газар, яамд, агентлаг, төрийн захиргааны болон олон улсын байгууллага, бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын уялдаа, зохицуулалтыг хангах;	Хамтын ажиллагааг өргөжүүлж, хуулийн хүрээнд ажилласан байна.	Ш, Г, Х
	5. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөх;	Дотоод журмын хүрээнд үйл ажиллагаагаа	Г,Х

		удирдан зохион байгуулсан байна.	
	6. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих;	Ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлсэн байна.	Г
	7. Байгууллагын төлөвшүүлэх соёлыг	Байгууллагын соёл төлөвшсөн байна.	Г
	8. Сургуулийн үйл ажиллагаанд удирдлага, мэдээллийн систем нэвтрүүлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, боловсролын удирдлага мэдээллийн системийн хэрэгжилтийг ханган ажиллах.	Ил тод нээлттэй бадлыг ханган ажилласан байна	
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	- Дээд боловсролтой байх		
Мэргэжил	- Боловсрол 0111 - Боловсрол судлал 011101 - Багш мэргэжлийн 0114		
Мэргэшил	Боловсролын удирдлага, төрийн удирдлага, бизнесийн удирдлагын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх		
Туршлага	<ul style="list-style-type: none"> - Ерөнхий боловсролын сургуульд 8 жил, үүнээс олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд үндсэн орон тоонд 4 болон түүнээс доошгүй жил багшилсан байх, эсхүл сургалтын менежерээр 3-аас доошгүй жил ажилласан байх; - Олон улсын боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтад хамрагдаж эрх авсан байх. 		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; - санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх; - байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх - багш, албан хаагчдын саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - төлөвлөлт, зохион байгуулалт сайтай, ажлын үр дүн гаргуулах; - багш, албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх, чиглүүлэх, шаардлага тавих; - бусад. 	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургалтын байгууллагын сургалт, судалгаатай холбоотой аливаа асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох; 	

		<ul style="list-style-type: none"> - мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа хийх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, үр дүнг тайлагнах; - болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглаж, үйл ажиллагааны боломжит хувилбарыг төлөвлөх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - бүтээлч, санаачлагатай ажиллах, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - бусад.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх; - эерэг уур амьсгал бүрдүүлэх; - итгэлцлийг бий болгох, албан хаагчдаа зөв шударгаар дүгнэх; - албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалт, зарчимч, ажил хэрэгч чанар, бүтээлч, санаачилга, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэн ажиллах; - эрх зүйн чадамжтай, өөрийнхөө үйлдлийг ухамсарлах чадвартай байх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөж, ёс зүйн шаардлагыг биелүүлэх; - ажлын цагийг баримтлан ажиллах; - жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - харилцааны соёлыг эрхэмлэн, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, монгол бичгийн найруулгын чадвартай байх; - гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;

	<ul style="list-style-type: none"> - бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах; - заах аргач түүнээс дээш зэрэгтэй байх; - англи хэлний өндөр түвшний мэдлэгтэй байх.
--	---

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Сургалтын менежер
- Нийгмийн ажилтан
- Багш, дотуур байрын багш
- Нягтлан бодогч, нярав
- Үйлчилгээний ажилтан

Бусад харилцах субъект

- Боловсрол, шинжлэх ухааны яамны газар, хэлтэс
- Боловсролын ерөнхий газар
- Аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газар, дүүргийн боловсролын хэлтэс
- Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
- Бусад төрийн болон төрийн бус байгууллагууд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ

..... /Г. Энхжаргал/
(Гарын үсэг)

Байгууллагын нэр:

Шийдвэрийн огноо:

2022 оны 11 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар:

Албан тушаалын тодорхойлолт баталсан

Байгууллагын нэр:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Шийдвэрийн огноо:

Дугаар: А/439

(тамга/тэмдэг)

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

(Гарын үсэг)



Г.ЭНХЖАРГАЛАН/

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2022 оны 11 дугаар сарын 02-ны өдөр